



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 16 өдөр

Дугаар А/274

Булган сум

Агаар мандалд зориудаар нөлөөлөх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4, 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.3, Тариалангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.1, 19.5.6 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны XII хуралдааны XII/90 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймгийн нутгаар дулааны улиралд цаг агаар тогтворгүй, олон жилийн дунджаас дулаан, салхи шуурга, хуурайшилт ихтэй байгаа нь бэлчээрийн ургамлын ургац, мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл, хаврын тариалалтад сөргөөр нөлөөлж болзошгүй тул шаардлагатай тохиолдолд 2026 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн агаар мандалд зориудаар нөлөөлж, хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулахыг Ус, цаг уур, орчны шинжилгээний төв (Б.Нандинбат)-д үүрэг болгосугай.

2.Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг зохицуулах дүрмийг мөрдөж, хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагааг олон улсын болон орон нутгийн нислэгийн аюулгүй байдалтай уялдуулан зохион байгуулж, хамтран ажиллахыг Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа “Булган” нисэх буудлын дарга (Д.Очирбат), Ус, цаг уур, орчны шинжилгээний төв (Б.Нандинбат) нарт тус тус даалгасугай.

3.Агаар мандалд зориудаар нөлөөлөх экспедицийг тухайн орон нутагт ажиллах нөхцөл, боломжоор хангаж ажиллахыг сумын Засаг дарга нарт чиглэл болгосугай.

4.Цаг агаарт зориудаар нөлөөлж, хур тунадас оруулах экспедицийн үйл ажиллагаанд шаардлагатай 15,900,000 (арван таван сая есөн зуун мянга) төгрөгийг Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас холбогдох бичиг баримтад үндэслэн санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Очирсүрэн)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



6326010371